

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
	2.1. Оршил	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
	2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
	2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
	2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
	2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
	2.12. Шилэн дансны мэдээлэл	8
	2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
	2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал	10
	1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал:	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
	4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
	4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
	4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХҮНС ТЭЖЭЭЛ, НИЙГМИЙН
ХАЛАМЖИЙН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Ц.БОЛОРМАА ТАНАА

2020.03.23 № 06/916
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй дүгнэлт

Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага


Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2 Аудитын тайлан

2.1. Оршил

Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төслийн зохицуулагч Ц.Болормаа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналыг сайжруулах, төслийн нэгжийн хөрөнгө ашиглалтад төрийн өмчийн холбогдох хууль тогтоомжийг баримтлах талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төслийн зохицуулагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор Н.Дэлгэрмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 20/5 дугаар бүхий албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд 2008 онд байгуулсан 0137-МОН буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж байгаа төслийг өргөжүүлэх зорилгоор 12,960,000 зээлжих тусгай эрхтэй тэнцэх 20.0 сая ам.долларын зээлийн хөрөнгийн нэмэлт санхүүжилтийн 3086-МОН гэрээг 2014 оны 2 дугаар сард хийсэн хэлэлцээрийн дүнд байгуулсан байна.

Нийгмийн даатгалын мэдээллийн системийг шинээр хөгжүүлж нэвтрүүлэх, нийгмийн даатгалын архивын цаасан суурьт баримтыг цахимжуулах ажлын гүйцэтгэлтэй уялдуулан төсөл хэрэгжих хугацааг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл сунгасан байна.

Төслийг зорилгыг “Монгол Улсын Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн мэдээллийн технологийн системийг шинэчлэх, нийгмийн хамгааллын бодлого, тогтолцоог бэхжүүлэх замаар нийгмийн хамгааллын салбарын үйл ажиллагаа, үйлчилгээг үр ашигтай, ил тод байдлаар хүргэхэд оршино.” гэж тодорхойлжээ

Уг төслийн зорилт нь нийгмийн халамж, нийгмийн даатгалын салбарын мэдээллийн технологийн үйл ажиллагаа, тогтолцоог шинэчлэн үйлчилгээний чанарыг сайжруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой болгон шинэчилж, нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулахад чиглэгдсэн байна.

Төслийн нийт хэрэгжилт 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 73 хувийн үзүүлэлттэй, зээлийн зарцуулалт 30.9 тэрбум төгрөг буюу 67.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

2019 оны 3 дугаар улирлаас худалдан авалтын төлөвлөгөөг шинэчлэн баталж, зөвлөх үйлчилгээний 11, бараа нийлүүлэлтийн 6 багцын худалдан авалт хийсэн байна.

Тайлант хугацаанд төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, бодлого журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төсөл нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагнал нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн нэгж нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны батлагдсан зардлын төсвийг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 7,087,402.5 мянган төгрөгөөс тооцон 70,874.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 61,409.3 мянган төгрөгөөр тогтоосон нь 2019 оны төсвийн зардлын гүйцэтгэлээс тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 788,385.7 мянган төгрөгөөр буюу 15.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, богино хугацаат өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,761,056.0	4,128,772.9	(632,283.10)
Авлага	162,545.4	19,687.3	(142,858.1)
Бараа материал	1,977.5	1,475.0	(502.5)
Үндсэн хөрөнгө	104,270.0	91,968.0	(12,302.0)
Биет бус хөрөнгө	1,246.7	806.7	(440.0)
Нийт хөрөнгийн дүн	5,031,095.6	4,242,709.9	(788,385.7)
Богино хугацаат өр төлбөр	27,264.2	1,462,230.1	1,434,965.9
Хуримтлагдсан үр дүн	5,003,831.4	2,780,479.8	(2,223,351.6)
Нийт өр төлбөр, Өмчийн дүн	5,031,095.6	4,242,709.9	(788,385.7)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь тайлант онд зөвлөх үйлчилгээний шинээр хийгдсэн 11 гэрээний төлбөр тооцоо хийгдсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх онд хийгдсэн GD-08/17 гэрээний бараа нийлүүлэлт хийгдсэн тул урьдчилгаа төлбөрийг зардлаар хүлээн зөвшөөрснөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх нэгж 23,605.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан дүнгээр нэмэгдэж, тайлант хугацааны элэгдлийн зардал 36,347.4 мянган төгрөгөөр хөрөнгийн цэвэр дүн буурснаас шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл өссөн нь тайлант онд хийгдсэн GD-06/17 гэрээний дагуу бараагаа бүрэн хүлээж авч зардлаар хүлээн зөвшөөрсөн учир гэрээний төлбөр тооцооны үлдэгдэл 1,462,230.8 мянган төгрөгөөр өглөгийн үлдэгдэл нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга нь 48,664.3 мянган төгрөг нь өмнөх онд хэрэгжсэн худалдан авалтын гэрээний баталгааны 5 хувийн барьцаа хөрөнгийг тайлант онд төлж, зардлаар хүлээн зөвшөөрснийг өмнөх оны үр дүнд залруулан тайлагнасанатай холбоотой байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийг хэрэгжүүлэхэд зориулж 2019 онд 7,087,402.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 5,410,247.7 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож, 76.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 2. Орлогын гүйцэтгэл

Санхүүжилт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
			Зөрүү	Хувь
Зээлийн санхүүжилт-Урсгал зардал	5,287,402.5	4,783,578.4	503,824.1	90.5
Зээлийн санхүүжилт-Хөрөнгө оруулалт	1,800,000.0	626,669.3	1,173,330.7	34.8
Нийт дүн	7,087,402.5	5,410,247.7	1,677,154.8	76.3

Тайлант онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт 7,087,402.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 5,287,402.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 1,800,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгийн зардалд 1,800,000.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 2,119,265.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Хөрөнгийн зардлыг АХБ-ны шууд төлбөрөөр 626,669.3 мянган төгрөг, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 1,492,596.2 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Урсгал зардалд 5,287,402.5 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 4,021,660.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нийт төсвийн гүйцэтгэл 1,677,154.8 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь зарим ажлууд хугацаандаа хэрэгжих боломжгүй тул төслийн хэрэгжих хугацааг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл сунгаж, хойшлуулсантай холбоотой байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл тодорхойлж, нийт 13 горим сорилын хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 53,971.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 53,971.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 1 асуудлаар зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 3 асуудлаар нийт 53,971.9 мянган төгрөгийн алдааг залруулан тайлагнасан. Үүнд:

1. Өмнөх онд хэрэгжсэн худалдан авалтын баталгааны 5 хувийн барьцааны өглөг 48,664.3 мянган төгрөгийг тайлант онд төлж, зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө",
2. Тендерийн 600.0 мянган төгрөгийн орлогоос 294.0 мянган төгрөгийн зарлага гарч суутган тооцсон 306.0 мянган төгрөгөөр орлогыг тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах
3. АХБ-наас зөвшөөрөгдөн Төсөл хэрэгжүүлэх нэгжид үндсэн хөрөнгө худалдан авснаас 5,013.8 мянган төгрөгийн хөрөнгийг зөвшөөрөлгүй яаманд шилжүүлэн өгч, зардлаар бүртгэсэн нь ТБОНӨТХ-ийн 2.4-д "төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй бусад байгууллагад шилжүүлсэн үндсэн хөрөнгийг буцаан бүртгэж, залруулсан боловч холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татах асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 61 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2 алдаа зөрчил илрүүлж, үүнээс 2 асуудлаар зөвлөмж өгснөөс 100 хувь буюу бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт:

Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт

Төсөл хэрэгжүүлэх нэгжид АХБ-наас зөвшөөрөгдөн худалдан авсан үндсэн хөрөнгөнөөс 5,013.8 мянган төгрөгийн хөрөнгийг зөвшөөрөлгүй яаманд шилжүүлэн өгч, зардлаар бүртгэсэн нь ТБОНӨТХ-ийн 2.4-д "төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах" гэсэнд нийцээгүй байна.

2.2 Эрсдэл

Хөрөнгөнд тавих хяналт сул байснаас хөрөнгө үрэгдэх, завших

2.3 Өгсөн зөвлөмж

Аудитын явцад дээрх зардлыг залруулан үндсэн хөрөнгийг бүртгэж, тайлагнасан боловч цаашид хууль тогтоомжийг биелүүлж хөрөнгийг зохих газруудад уламжлан, зөвшөөрөл гарсны дараа данснаас хасч бүртгэх

2.4 Байгууллагаас өгсөн хариу

Зөвлөмжийг хүлээн авсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эхний үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	4,761,056,001.56	4,128,772,908.99
Кассад байгаа бэлэн мөнгө	-	500,000.00
Жижиг мөнгөн сан	-	500,000.00
Төгрөгийн харилцах данс	210,035,295.07	591,255,671.09
Төрийн сангийн харилцах данс	210,019,133.03	591,255,671.09
Төгрөгийн харилцах данс	16,162.04	-
Валютын харилцах данс	4,551,020,706.49	3,537,017,237.90
Валютын харилцах тусгай данс	4,039,523,501.44	3,537,017,237.90
Валютын харилцах дэд данс	511,497,205.05	-
АВЛАГА	162,545,387.83	19,687,290.00
Төлбөртэй үйлчилгээний авлага	161,668,470.00	19,687,290.00
Бусад авлага	876,917.83	-
БАРАА МАТЕРИАЛ	1,977,460.00	1,475,000.00
Сэлбэг хэрэгсэл	1,475,000.00	1,475,000.00
Түлш шатах тослох материал	502,460.00	-
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,925,578,849.39	4,149,935,198.99
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
Биет хөрөнгө	104,270,046.05	91,968,043.85
Авто тээврийн хэрэгсэл	125,613,300.00	125,613,300.00
Хуримтлагдсан элэгдэл	(57,021,735.64)	(69,583,065.64)
Машин, тоног төхөөрөмж	60,936,490.20	84,541,930.20
Хуримтлагдсан элэгдэл	(37,249,710.29)	(56,752,182.71)
Тавилга, аж ахуйн эд хогшил	20,003,476.00	20,003,476.00
Хуримтлагдсан элэгдэл	(8,011,774.22)	(11,855,414.00)
Биет бус хөрөнгө	1,246,666.67	806,666.67
Програм хангамж	1,320,000.00	1,320,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(73,333.33)	(513,333.33)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	105,516,712.72	92,774,710.52
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,031,095,562.11	4,242,709,909.51
Богино хугацаат өр төлбөр	27,264,198.61	1,462,230,077.00
Бусад өглөг	27,264,198.61	1,462,230,077.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	27,264,198.61	1,462,230,077.00
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	27,264,198.61	1,462,230,077.00
ЭЗНИЙ ӨМЧ		
Хуримтлагдсан үр дүн	5,003,831,363.50	2,780,479,832.51
Өмнөх үеийн үр дүн	5,003,831,363.50	4,955,167,075.00
Тайлант үеийн үр дүн	-	(2,174,687,242.49)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	5,003,831,363.50	2,780,479,832.51
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	5,031,095,562.11	4,242,709,909.51

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Өмнөх оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
Татаас санхүүжилтийн орлого	7,843,729,500.10	5,410,247,717.57
Зээлийн санхүүжилтийн орлого	2,564,446,704.10	4,783,578,435.69
Зээлийн шууд санхүүжилтийн орлого	5,279,282,796.00	626,669,281.88
Бараа ажил үйлчилгээний орлого	95,161,286.34	600,000.08
Хүүгийн орлого	94,561,286.34	0.08
Бусад орлого	600,000.00	600,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,938,890,786.44	5,410,847,717.65
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
Ажиллагчидтай холбоотой зардал	238,379,764.98	315,361,684.83
Цалин	213,143,017.67	280,321,497.56
Тэтгэврийн даатгалын шимтгэл	25,236,747.31	35,040,187.27
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,459,187.10	-
Байрны түрээс	16,459,187.10	-
Бусад бараа үйлчилгээний зардал	1,275,272,023.18	3,720,360,906.11
Бичиг хэргийн зардал	2,760,900.00	4,382,250.00
Тээвэр, шатахуун, сэлбэгийн зардал	1,890,000.00	7,564,712.00
Шуудан, холбоо, интернэтийн зардал	3,387,864.78	3,885,533.05
Хангамжийн зүйлсийн зардал	1,961,880.00	1,515,650.00
Урсгал засварын зардал	2,071,850.00	1,230,800.00
Зар сурталчилгааны зардал	-	7,840,000.00
Дотоод томилолтын зардал	-	1,221,800.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг зардал	965,227,785.70	3,464,347,960.57
Аудит, баталгаажуулах үйлчилгээний зардал	7,800,000.00	16,958,788.29
Татвар, хураамж, даатгалын зардал	3,432,667.87	171,720.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	84,431.04	171,093.20
Бараа үйлчилгээний бусад зардал	250,673,868.26	174,723,156.80
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,980,775.53	36,347,442.20
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,307,266,702.50	3,647,901,034.44
Тоног төхөөрөмж	5,307,266,702.50	3,647,901,034.44
Тавилга, эд хогшил	-	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	6,837,377,677.76	7,683,623,625.38
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,101,513,108.68	(2,272,775,907.73)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	403,492,115.42	98,088,665.24
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	403,492,115.42	98,088,665.24
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	44,196,083.92	-
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	44,196,083.92	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,460,809,140.18	(2,174,687,242.49)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
Татаас санхүүжилтийн орлого	7,843,729,500.10	5,410,247,717.57
Зээлийн санхүүжилтийн орлого	7,843,729,500.10	5,410,247,717.57
Бараа, ажил үйлчилгээний орлого	105,161,286.34	85,963,618.81
Хүүгийн орлого	94,561,286.34	85,363,618.81
Бусад орлого	10,600,000.00	600,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	7,948,890,786.44	5,496,211,336.38
Ажиллагчидтай холбоотой зардал	238,379,764.98	315,361,685.22
Цалин	213,143,017.67	254,843,289.43
Тэтгэврийн даатгалын шимтгэл	25,236,747.31	60,518,395.79
Тогмол зардал	12,954,387.10	-
Байрны түрээс	12,954,387.10	-
Хангамж, бараа материалын зардал	12,574,954.78	18,076,485.05
Бичиг хэрэг	2,760,900.00	4,382,250.00
Тээвэр, шатахуун	2,392,460.00	7,062,252.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,387,864.78	3,885,533.05
Хангамжийн зүйлс	1,961,880.00	1,515,650.00
Урсгал засвар	2,071,850.00	1,230,800.00
Томиллолт, зочны зардал	-	1,221,800.00
Дотоод албан томиллолт	-	1,221,800.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,000,480,845.77	3,488,965,435.96
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	989,163,746.86	3,463,823,834.47
Мэдээлэл, сурталчилгааны зардал	-	7,840,000.00
Аудит, баталгаажуулах үйлчилгээний зардал	7,800,000.00	16,958,788.29
Татвар, хураамж, даатгалын зардал	3,432,667.87	171,720.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	84,431.04	171,093.20
Бараа үйлчилгээний бусад зардал	250,673,868.26	260,086,775.53
Бараа үйлчилгээний бусад зардал	250,673,868.26	174,723,156.80
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	85,363,618.73
Капиталжаагүй хөрөнгө оруулалтын зардал	5,422,336,476.00	2,119,265,471.44
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	6,937,400,296.89	6,202,977,653.20
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(III)=(I)-(II)	1,011,490,489.55	(706,766,316.82)
Төсвийн хөрөнгөөр биет бус хөрөнгө худалдан авсан	(1,320,000.00)	(23,605,440.00)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,320,000.00)	(23,605,440.00)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	359,296,031.50	98,088,664.25
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИ	359,296,031.50	98,088,664.25
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,369,466,521.05	(632,283,092.57)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,391,589,480.51	4,761,056,001.56
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,761,056,001.56	4,128,772,908.99

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	-	-	3,539,517,423.32	3,539,517,423.32
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			3,504,800.00	3,504,800.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			3,543,022,223.32	3,543,022,223.32
4	Тайлант үеийн үр дүн			1,460,809,140.18	1,460,809,140.18
5	2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	-	-	5,003,831,363.50	5,003,831,363.50
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(48,664,288.50)	(48,664,288.50)
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			4,955,167,075.00	4,955,167,075.00
8	Хөрөнгийн үнэлгээний өсөлт, бууралт				-
9	Тайлант үеийн үр дүн			(2,174,687,242.49)	(2,174,687,242.49)
10	2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	-	-	2,780,479,832.51	2,780,479,832.51

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
1	I. НИЙТ ЗАРДАЛ БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,087,402,500.00	6,140,925,474.47	946,477,025.53	87%
2	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	5,287,402,500.00	4,021,660,003.03	1,265,742,496.97	76%
3	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,287,402,500.00	4,021,660,003.03	1,265,742,496.97	76%
4	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,168,000.00	-	3,168,000.00	0%
5	Түрээсийн зардал	3,168,000.00	-	3,168,000.00	0%
6	Хангамж, бараа материалын зардал	32,320,000.00	17,782,485.05	14,537,514.95	55%
7	Бичиг хэргиний зардал	4,984,000.00	4,088,250.00	895,750.00	82%
8	Тээвэр, шатахууны зардал	17,880,000.00	7,062,252.00	10,817,748.00	39%
9	Шуудан, холбооны зардал	4,896,000.00	3,885,533.05	1,010,466.95	79%
10	Хангамжийн зардал	2,560,000.00	1,515,650.00	1,044,350.00	59%
11	Урсгал засварын зардал	2,000,000.00	1,230,800.00	769,200.00	62%
12	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,939,404,500.00	3,969,983,260.38	969,421,239.62	80%
13	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,939,404,500.00	3,969,983,260.38	969,421,239.62	80%
14	Бараа үйлчилгээний бусад зардал	312,510,000.00	33,894,257.60	278,615,742.40	11%
15	Бараа үйлчилгээний бусад зардал	312,510,000.00	33,894,257.60	278,615,742.40	11%
16	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ	1,800,000,000.00	2,119,265,471.44	(319,265,471.44)	118%
17	Тоног төхөөрөмж	1,800,000,000.00	2,119,265,471.44	(319,265,471.44)	118%
18	ТХН-ийн үндсэн хөрөнгө	-	-	-	
19	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,087,402,500.00	5,410,553,717.65	1,676,848,782.35	75%
20	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	85,963,618.81	(85,963,618.81)	
21	Хүүгийн орлого		85,363,618.81	(85,363,618.81)	
22	Бусад орлого		600,000.00	(600,000.00)	
23	Эх үүсвэрээс санхүүжих	7,087,402,500.00	5,324,590,098.84	1,762,812,401.16	75%
24	Зээлийн санхүүжилт	7,087,402,500.00	5,324,590,098.84	1,762,812,401.16	75%
25	Буцалтгүй тусламжийн санхүүжилт				
26	Тохируулгын дүн		98,088,664.25		
27	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,761,056,001.56		
28	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,128,772,908.99		
29	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
30	Байгууллагын тоо	1			
31	Ажиллагсдын тоо	7			
32	Удирдах ажилтан	1			
33	Гүйцэтгэх ажилтан	6			

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2020/151/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төсөл			Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	З	4.0	5	8	9
1	АХБ-наас зөвшөөрөгдөн Төсөл хэрэгжүүлэх нэгжид үндсэн хөрөнгө худалдан авснаас 5,013.8 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох газрын зөвшөөрөлгүй яаманд шилжүүлэн өгч, зардлаар бүртгэсэн	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан	Ц.Болормаа С.Оюунцэцэг
Нийт дүн		-			